



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 1 дүгээр сарын 12 өдөр Дугаар 03

Хэрлэн сум

III ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 3 дугаар хуралдаан 2021 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 15:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 95,6 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсурэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Дэн буудлуудыг тусгаарлах байраар ашиглах боломжтой эсэх талаар хэлэлцэх,

Мэргэжлийн хяналтын газар

2.Сургалтын төв, спорт заалны үйл ажиллагааг хязгаарлалттайгаар нээх эсэх талаар хэлэлцэх,

Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар

3.Аймгийн хэмжээнд еренхий боловсролын сургуулийн 12 дугаар ангид хичээл заадаг 125 багш наарт танхимын сургалт зохион байгуулах тухай хүсэлт, ахлах ангийн сурагчдын давтлага хичээлийг эхлүүлэх тухай хүсэлтийг хэлэлцэх,

Боловсрол, соёл урлагийн газар

4.Баян-Уул, Цагаан-Овоо суманд ажиллахад гарсан ажлын санал танилцуулах,

АЗДТГ-ын ХОХБТХэлтэс

5.Чойбалсан хотод үйл ажиллагаа явуулдаг шатахуун борлуулдаг компаниудын удирдлагуудтай уулзалт зохион байгуулсан талаар танилцуулах,

Бусийн төв аймгийн Онцгой байдлын газар

6.Аймгийн Онцгой комисст иргэд, аж ахуй нэгж байгууллагуудаас ирүүлсэн хүсэлт, албан бичгийг танилцуулах,

Бусийн төв аймгийн Онцгой байдлын газар

7.Хот хооронд зорчих түр журмын талаар хэлэлцэх,

Эрүүл мэндийн газар

Бусийн төв аймгийн Онцгой байдлын газар

/ C.Dn / М.Бадамсурэн
[Signature] я-гүчинчлийн

8. Согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх цагийн хязгаарлалтыг 14 хоногоор сунгах эсэх талаар хэлэлцэх,

Цагдаагийн газар

9. Ахуйн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагааны талаар мэдээлэл танилцуулах,

Бусийн төв аймгийн Онцгой байдлын газар

10. Хүндэтгэн үзэх шалтгаантай иргэдийг татан авах талаар хэлэлцэх,

Бусийн төв аймгийн Онцгой байдлын газар
Эрүүл мэндийн газар

11. Сум, багийн иргэдийн нийтийн хурлын товыг хэлэлцэх,

АЗДТГ-ын Төрийн захираааны удирлааын хэлтэс

12. Дотоодын хүмүүнлэгийн тусlamжийн мэдээлэл танилцуулах,

Бусийн төв аймгийн Онцгой байдлын газар

13. Малын вакцины хэрэглэсэн шил, савыг устгах талаар хэлэлцэх,

Мал эмнэлгийн газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д. Менхтуяа-д:

1.1. Дэн буудлуудын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллахыг,

Бусийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г. Нармандаа.

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д. Менхтуяа,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч. Оюунаа.

Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч,
Онцгой комиссын гишүүн О. Пүрэв-Очир нарт.

1.2. Дорнод аймагт үйл ажиллагаа зэрхэлдэг дэн буудлуудыг тусгаарлах байрны зориулалтаар ашиглах боломжтой эсэх талаар мэргэжлийн байгууллагын бүрэлдэхүүн оролцсон ажлын хэсэг хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж аймгийн Онцгой комиссын дараагийн хуралдаанд танилцуулахыг,


Хоёр. Бусийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г. Нармандаа.

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д. Менхтуяа,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч. Оюунаа.

Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч,
Онцгой комиссын гишүүн О. Пүрэв-Очир нарт.

2.1. Спорт заалны үйл ажиллагаанд хяналт, шалгалт зохион байгуулсан тухай мэдээллийг олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж, иргэдийг мэдээллээр хангахыг,

/  / М.Бадамсүрэн
 / З.Ганжигүүр

2.2. Спорт заалны үйл ажиллагаанд хяналт, шалгалт зохион байгуулах ажлын хэсгийг Эруул мэндийн газар ахлах, нарийн бичгийн даргаар Мэргэжлийн хяналтын газар, гишүүдээр Бусийн төв аймгийн Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын бүрэлдэхүүнтэй томилж ажлыг зохион байгуулахыг,

Гурав. Бусийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Менхтуяа,
Эруул мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Боловсрол, соёл урлагийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн А.Нансалмаа, сумын Засаг дарга нарт.

3.1. Бага, дунд, ангийн сурагчдад хичээл, давтлага орохыг хориглохыг,

3.2. Еренхий боловсролын сургууль, сургалтын төвд мэргэжлийн байгууллагудын бүрэлдэхүүнтэй хяналт, шалгалтын ажлын хэсэг томилж ажиллуулах, халдварт хамгаалал, агаар сэлгэлт, хеделгээнд хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулсан мэдээллийг аймгийн Онцгой комиссын дараагийн хуралдаанд танилцуулахыг,

3.3. Сургалтын төв, Еренхий боловсролын сургуулийн 9,10,11,12 дугаар ангийн сурагчдын танхимын давтлага хичээлийг эхлүүлэх чиглэлээр сургууль, эзэг эх, багш нарын гурван талт гэрээ байгуулахад хяналт тавьж ажиллахыг,

3.4. Боловсрол, соёл урлагийн газраас аймгийн Онцгой комисст ирүүлсэн хүсэлтийн дагуу аймгийн төвийн багш нарыг 1 танхимд 10-аас дээшгүй хүнтэй, халдварт хамгааллын дэглэм баримтлах, хүн хоорондын зайг /2 метр/ баримтлан сургалт зохион байгуулахыг зөвшөөрөхийг,

Бусийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Менхтуяа,
Эруул мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
"Дорнод нийтийн аж ахуй" ОНӨААТҮГ-ын дарга,
Онцгой комиссын гишүүн Г.Баярсайхан нарт.

3.5. Хедалмэр халамжийн үйлчилгээний газрын харьяа "Ахмадын өвлийн амралт, сувиллын газар"-ыг тусгаарлах байраар ашиглах боломжтой эсэх талаар дүгнэлт гаргахыг,

3.6. "Дорнод политехник коллеж"-ийн турээслэж буй 4 давхар барилгыг тусгаарлах байраар ашиглах боломжтой эсэх талаар дүгнэлт гаргахыг,

Боловсрол, соёл урлагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн А.Нансалмаа-д;

3.7. Сумдын өрөнхий боловсролын сургуулийн багш нарт Боловсрол, соёл урлагийн газраас ажлын хэсэг томилж сургалт зохион байгуулахыг зөвшөөрөв,

Дөрөв. АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,
Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ-д.

4.1. Өөр аймгийн сумдтай хил залгаа амьдардаг сумдын малчин өрхүүдтэй гэрээ байгуулж, хууль бус тээврийн хэрэгслийн мэдээлэл шуурхай авах ажлыг зохион байгуулахыг,

 / M. Бадамсүрэн
 / Э. Ганжигүүр

4.2. Сумдын хяналтын цагт шаардлагатай дуранг хангах талаар сумын Засаг дарга нарт чиглэл өгөхийг,

4.3. Баян-Уул суманд хяналтын цэг нэмэгдүүлэхэд шаардагдах 500,000 /таван зуун мянга/ төгрөг, Цагаан-Овоо суманд хяналтын цэг нэмэгдүүлэхэд шаардагдах 500,000 /таван зуун мянга/ төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж, Засаг даргын неец хөрөнгөөс шийдвэрлүүлэхийг,

4.4. Сумдын Засаг дарга нарт Хөлөнбүр сумын автозам дагуу байгуулсан төв хяналтын цэгээр нэвтрэсэн сумын иргэд, тээврийн хэрэгслийн мэдээллийг шуурхай авч байх тухай албан бичгээр үүрэгжүүлэхийг,

Бусийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

4.5. Цагаан-Овоо сумын тусгаарлах байраар ашиглах сургуулийн дотуур байр, соёлын төвд 2 ширхэг, Баян-Уул сумын сургуулийн дотуур байранд 1 ширхэг хяналтын камер шинээр суурилуулахад шаардагдах зардлын тооцоог гаргаж танилцуулахыг,

4.6. Буяны байгууллага, лам хуврагаар үйлчлүүлж буй иргэдэд коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр Улсын болон аймгийн Онцгой комиссын гарсан шийдвэр, заавар зөвлөмжийг мөрдүүлж ажиллах талаар сумдын Засаг дарга нарт албан бичгээр чиглэл хүргүүлэхийг,

4.7. Буяны ажилд оролцох иргэдэд коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх халдварт хамгааллын дэглэмийг мөрдүүлэх, хяналт тавьж ажиллах талаар сумын Засаг дарга нарт үүрэг хүргүүлэхийг,

4.8. Сумдын соёлын төв, дотуур байрны камержуулалтын талаарх судалгааг авах, дүгнэлт гаргах талаар сумын Засаг дарга нарт албан бичиг хүргүүлэхийг,

Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч дарга Ч.Ганбат-д:

4.9. Сумдын тусгаарлах байрыг камерын хяналтад оруулах талаар сумын Засаг дарга нарт чиглэл өгч шийдвэрлүүлэхийг,

4.10. Сумдын шатахуун түгзэх станцаар үйлчлүүлж буй иргэд, тээврийн хэрэгслийг бүртгэх, бүртгэлд хяналт тавьж ажиллах талаар сумын Засаг дарга нарт албан бичгээр чиглэл хүргүүлэхийг,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Менхтуяа-д:

4.11. Дэлгүүр, үйлчилгээний байгууллагуудаар үйлчлүүлж буй иргэдийг асуумж бэглүүлж хэвшүүлэх, бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулах талаар аж ахуй нэгж байгууллагуудад чиглэл хүргүүлэхийг,

АЗДТГ-ЫН Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Баяржаргал,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг нарт;

4.12. Сумдад олон нийтийн цагдааг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах, албан хаагч ажиллах зардлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас шийдвэрлүүлэхийг,

Бусийн төв аймгийн Онцгой байдлын газрын орлогч дарга, Онцгой комиссын нарийн бичгийн дарга, дэд хурандаа Д.Баттулга,

 / M. Бадамсүрэн
 / Э. Ганжинигүүр

Бүсийн оношилгоо змчилгээний төвийн тархвар
судлаач, эмч Б.Ганганцацг нарт:

4.13. Коронавируст халдварт /COVID-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх талаар зөвлөмжийг цахим хуудсаар тогтмол үе шаттай мэдээлж хөгжлүүлах ажлыг зохион байгуулах, "Дорнод Шуурхай штаб" фэйсбууц хаягыг олон нийтэд таниулахыг,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
цагдаагийн хурандаа Т.Ганзориг нарт:

4.14. Цагаан-Овоо сумын хяналтын цэгт албан хаагч томилж, ажиллах хүчийг нэмэгдүүлэхийг,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа-д:

4.15. Суманд тусгаарлах байр бэлтгэх зөвлөмжийг боловсруулж сумын Онцгой комиссийн хүргүүлэх, тусгаарлах байр нэмэгдүүлэхэд хяналт тавьж ажиллахыг,

АЗДТГ-ын Санхүү, тврийн сангийн хэлтсийн дарга,
Онцгой комиссын гишүүн В.Цэнгэлмаа,
Боловсрол, соёл урлагийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн А.Нансалмаа нарт:

4.16. Ерөнхий боловсролын сургуулийн танхимины сургалт эхлэх бэлтгэл ажил хангуулахтай холбогдуулан ариутгалын бодис, халдварт хамгааллын хувцас, хэрэгслийн зардлыг урсгал зардлаас шийдвэрлэх талаар сумын Засаг дарга, Ерөнхий боловсролын сургуулийн захирлуудад чиглэл өгөхийг.

Тав. Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

5.1. Халдварт голомттой бус нутгаас шатахуун тээвэрлэх үйл ажиллагааг түр хориглох тухай аймгийн Онцгой комиссын тогтоол боловсруулж баталгаажуулахыг,

5.2. Аймгийн Онцгой комиссоос гарсан тогтоолд Онцгой комиссын дарга, Онцгой комиссын нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурж баталгаажуулахыг,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Менхтуяа-д:

5.3. Баянтүмэн сумын нутагт Улаанбаатар хотоос шатахуун тээвэрлэсэн автомашин осол гаргаж хөрсен дээр шатахуун асгарсантай холбогдуулан Петрочайна Дачин Тамсаг ХХК, шатахуун тээвэрлэгч байгууллага, хангандийлүүлэгч байгууллагад албан шаардлага хүргүүлэхийг,

5.4. Байгаль орчинд учирсан хохиролд үнзлгээ хийлгэх, хууль хяналтын байгууллагад шилжүүлж хохирлыг нөхөн телүүлэх,

5.5. Хохирол учирсан орчин, газар нутгийг цэвэрлэх ажлыг тухайн компаниар шийдвэрлүүлэхийг,


/ М.Бадамсүрэн

/ Э.Ганжигүүр

Зургаа. Бусийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга,
Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
цаагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа нарт;

6.1. Улсын Онцгой комисс, Зэвсэгт хүчний 327 дугаар ангиас аймгийн Онцгой комисст ирүүлсэн "Дорнод аймагт шалгалтын албан хаагчийг хамруулах, 2м-ээс доошгүй зайд хэмжээг баримталж мөрдүүлэх, Онцгой байдлын газар, Цагдаагийн газрын албан хаагч нар тогтолт хяналт тавьж ажиллуулах, шалгалтад хамрагдсан тусангийн албан хаагч нарыг 7 хоногийн тусгаарлалтад байрлуулж, урьдчилсан шинжилгээнд хамруулж хариу серег гарсан тохиолдолд хэвийн горимд шилжүүлж ажиллахыг,

6.2. Улаанбаатар темер замын Баянтумэн тасгаас аймгийн Онцгой комисст ирүүлсэн "Улаанбаатар темер замын Багануур өртөөнөөс тээвэрлэлт хийх" хүснэгтийг хэлэлцэж аймгийн Онцгой комиссын дараагийн хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлэхийг,

6.3. "Энерго сервис монтаж" ХХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн "Дорнод аймагт ажилчид нэвтрэх" хүснэгтийн дагуу тус компанийн 8 ажилчдыг тусгаарлах байранд тусгаарлах, камерын хяналт тавих, Цагдаагийн газар, Онцгой байдлын газрын албан хаагч нарын хяналт тавьж ажиллуулах, ажиллах нахцел бурдуулэх зорилгоор гэр барих, 8 ажилчдыг өөрсдийн зардлаар 7, 14 хоногийн шинжилгээнд хамруулах шаардлагуудыг зөвшөөрсөн тохиолдолд нэвтрүүлэхийг,

6.4. "Стэл голд" ХХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн "Дорнод аймагт засварчид нэвтрүүлэх тухай" хүснэгтийн дагуу халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэх, хослыг өөрсдеер нь хийлгэх, камерын хяналт тавих, тусгаарлах байрыг түгжих, Цагдаагийн газар, Онцгой байдлын газрын албан хаагч нарыг томилж ажиллуулах, шаардагдах шатахуун, томилолтын зардлыг тухайн байгууллага хариуцаж шийдвэрлэхийг зөвшөөрсөн тохиолдолд хүснэгтийн дагуу нэвтрүүлэхийг,

6.5. "Дорнод гурил" ХХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн "Дэмжлэг хүсэх тухай" албан бичгийн дагуу Улсын Онцгой комиссын дарга, Монгол Улсын Шадар сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга нарт албан бичгээр уламжлахыг,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа-д:

6.6. "Дорнод гурил" ХХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн "Дэмжлэг хүсэх тухай" албан бичгийн хариуг мэдэгдэхийг,

Долоо. Бусийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

7.1. Хот хоорондын зорчигч тээврийн хөдөлгөөнийг зохицуулах түр журмыг боловсруулж батлуулахыг,

7.2. Аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргын 2020 онд баталсан "Ачаа тээврийн хөдөлгөөнийг зохицуулах түр журам"-ыг аймгийн Онцгой комиссоос гарсан шийдвэрийг үндэслэн шинэчлэн батлуулахыг,

/ Дн / М.Бадамсүрэн
/ Ганжигүүр / Г.Ганжигүүр

АЗДТГ-ын Олон нийттэй харилцах албаны дарга, Онцгой комиссын
гишүүн Э.Батболд-д:

7.3. Нийслэл Улаанбаатар хотод байгаа иргэдэд аймгийн Онцгой комиссоос гаргасан шийдвэр, мэдээ мэдээллийг бүх төрлийн мадаэллийн хэргэслээр хүргэхийг,

Нийм АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Онцгой комиссын
гишүүн Ц.Баяржаргал,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишигүүн,
цагдаагийн хурандaa Т.Ганзориг нарт:

8.1. Согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх цагийн хязгаарлалт тогтоохыг 14 хоногоор сунгах тухай аймгийн Засаг даргын захирамж гаргуулахыг,

Бусийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандaa Г.Нармандах-д:

8.2. Аймгийн Шуурхай штабт аймгийн Онцгой комиссын гишигүүдийг томилж ажиллуулах, ажиллах хуваарийг боловсруулж батлуулахыг,

Ес.Терийн болон териийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн дарга,
сумын Засаг дарга нарт:

9.1. Ахуйн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж ажиллахыг,

Арав.Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын
орлогч дарга Ч.Ганбат-д:

10.1. Сумын Засаг дарга нарт аймгийн Шуурхай штабаас утсан холбоогоор холбогдох нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллах талаар албан бичгээр чиглэл хүргүүлэхийг,

Аймгийн Онцгой комиссын нийт гишигүүдэд:

10.2. Аймгийн Онцгой комиссын хуралдаанаас гаргасан үүргийн биелэлтийг хариуцсан албан тушаалтыг байгууллагын хэмжээнд томилж, аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргад танилцуулахыг,

Бусийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандaa Г.Нармандах,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишигүүн Ч.Оюунаа нарт:

10.3. Хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээг автобусаар 7 хоногт 1 удаа зохион байгуулалттайгаар иргэдийг татан авах ажлын бэлтгэл хангахыг,

/  / М.Бадамсүрэн
 Э.Ганжигүүр

Арван нэг АЗДТГ-ын Терийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,
Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ-д:

11.1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газрын албан хаагчдын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулах, сум, багийн иргэдийн нийтийн хурал зохион байгуулах журам боловсруулж аймгийн Онцгой комиссын 2021 оны 5 дугаар хуралдаанд танилцуулахыг,

Арван хоёр Бусийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга,
Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

12.1. Баян-Уул, Цагаан-Овоо суманд аймгийн Онцгой комиссоос томилогдсон ажлын хэсгийн шатахууны 540,000 төгрөгийн зардлыг Дотоодын хүмүүнлэгийн тусlamжаас Бусийн төв аймгийн Онцгой байдлын газарт олгохыг,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
цагдаагийн хурандаа Т.Ганзориг-д:

12.2. Эрзэнцав хилийн боомтод Цагдаагийн албан хаагч наарт 30 хоног үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай нүүрс, хоол, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардал 1,704,600 /нэг сая долоон зуун дөрвөн мянга зургаан зуу/ төгрөгийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэхийг,

Арван гурав Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мэнхтуяа-д:

13.1. Малын вакцины хэрэглээ, ашиглалтад хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулах, аж ахуй нэгж байгууллагуудад мэдэгдэл хүргүүлж ажиллахыг,

Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Аюушмаа наарт:

13.2. Малын вакцины хэрэглээ, ашиглалтын тухай хууль, дүрэм, стандартын дагуу аж ахуй нэгж байгууллагуудад зөвлөмж, чиглэлийг албан бичгээр хүргүүлэхийг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГА

М.БАДАМСҮРЭН

БУСИЙН ТӨВ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН
ПРОГРАММ, ТЕХНИК ХАНГАМЖ ХАРИУЦСАН
ИНЖЕНЕР, АХМАД

Хамад

Э.ГАРЖИГҮҮР